



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/115

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Монгол орны үзэсгэлэнт байгаль, түүхэн дурсгалт газрууд” төслийн хүрээнд аймаг, сум, орон нутгийн байгалийн түүхэн дурсгалт газар болон түүх соёлын биет болон биет бус өвийг олон нийтэд сурталчлан таниулах контент нэвтрүүлгийн зардалд 1360000 (нэг сая гурван зуун жаран мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Контент нэвтрүүлгийн зардалд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.


3. Дээрх зардалд шаардагдах 1360000 (нэг сая гурван зуун жаран мянга) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2021 оны 07-р сарын 09-ны өдрийн 1115 дугаар захирамжийн хавсралт



“МОНГОЛ ОРНЫ ҮЗЭСГЭЛЭНТ БАЙГАЛЬ,  
ТҮҮХЭН ДУРСГАЛТ ГАЗРУУД” НЭВТРҮҮЛГИЙН  
БЭЛТГЭЛ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

2021.07.09

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Ажлын хөлс	1	1.000.000	1.000.000
2	Хоол /өдөр, орой/	30	8000	240.000
3	Бензин /1 машинд 30000	4	30.000	120.000
<b>Нийт</b>				<b>1.360.000</b>